



Оо хоног тутмын хэвлэл
оны 11 дүгээр сарын 25
№44 /617/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хууль

**Төрийн албаны тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай**

928

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

**Монгол Улсын Засгийн газрын
гишүүдийг томилох тухай**

930

Монгол Улсын Дээд
Шүүхийн тогтоол

**Иргэний хэрэг шүүхэд хянан
шийдвэрлэх тухай хуулийн 44
дүгээр зүйлийн 44.4 дэх хэсгийг
тайлбарлах тухай**

949

Улаанбаатар хот
2009 он

Улсын Их Хурлын Тамгын Газар

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

562. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 928

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

563. Прокурорын байгууллага байгуулагдсаны 80 жилийн ойг тэмдэглэх тухай Дугаар 70 929
564. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай Дугаар 71 929
565. Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай Дугаар 72 930
566. Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг чөлөөлөх тухай Дугаар 73 931
567. Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 74 932

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

568. Рээдхүмбийн Төмөрбаатарт Монгол Улсын Гавъяат механикжуулагч цол хүргэх тухай Дугаар 135 933
569. Одон, медалиар шагнах тухай Дугаар 136 933

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

570. Тогтоод өөрчлөлт оруулах тухай Дугаар 223 934
571. Зарим төслүүдийн санхүүжилтийн тухай Дугаар 225 935
572. Журам батлах тухай Дугаар 227 936
573. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө бэлтгэх ажлыг журамлах тухай Дугаар 234 940
574. Үндэсний стратегийг сайшаах тухай Дугаар 239 941
575. Жагсаалт батлах тухай Дугаар 246 942
576. Автогэврийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 251 944

577.	Тэмцээн зохион байгуулах тухай	Дугаар 252	946
578.	Нэрэмжит болгох тухай	Дугаар 254	946
579.	Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийн эсрэг авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 255	947
580.	Агентаг байгуулах тухай	Дугаар 257	948
МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ			
581.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсгийг тайлбарлах тухай	Дугаар 30	949

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.1.2. боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг зэрэг улсын төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах ба гүйцэтгэх, туслах албан тушаал”.

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтын “төсвийн бусад байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх дарга (захирал, эрхлэгч)” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2009 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ2009 оны 11 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот**Прокурорын байгууллага байгуулагдсаны
80 жилийн ойг тэмдэглэх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад прокурорын байгууллага байгуулагдсаны 80 жилийн ойг 2010 оны 8 дугаар сарын эхний долоо хоногт тэмдэглэхээр тогтоосугай.

2. Прокурорын байгууллага байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг 2010 оны улсын төсөвт тусган шийдвэрлүүлэхийг Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ****МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2009 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар
хот**Засгийн газрын бүтэц,
бүрэлдэхүүний тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2009 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр ирүүлсэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай 2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан хуулиудаар тогтоосон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнээр ажиллахыг Монгол Улсын Ерөнхий сайд /С.Батболд/-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг 2009 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ**



8/Халтмаагийн Баттулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын;

9/Төгсжаргалын Гандийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын;

10/Түнжингийн Бадамжунайг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын;

11/Дашдоржийн Зоригтыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын;

12/Самбуугийн Ламбааг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдын;

13/Бадраагийн Долгорыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын.

2. Энэ тогтоолыг 2009 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 11 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар
хот

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Ринчөөнямын Амаржаргалыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2009 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2009 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар
хот**Рээлхүмбийн Төмөрбаатарт Монгол Улсын
Гавъяат механикжуулагч цол хүртээх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн арван тавдугаар зүйлийн нэгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, бүс нутгийн газар тариалангийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан "Элсэн цагаан" ХХК-ний гүйцэтгэх захирал Рээлхүмбийн Төмөрбаатарт Монгол Улсын Гавъяат механикжуулагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Ц.ЭЛБЭГДОРЖ****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2009 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 136

Улаанбаатар
хот**Одон, медалиар шагнах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн арван тавдугаар зүйлийн нэгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, бүс нутгийн газар тариалангийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан доорхи хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН

Батын Энэбиш - "Өнөрбулагтай" ХХК-ний захирал

Аюушийн Алдар - "Зүүн Ивэн Бургалтай" ХХК-ний трактор-комбайнч

Дашдоржийн Нэргүй - "Мөнх шижир тариа" ХХК-ний трактор-комбайнч

АЛТАН ГАДАС ОДОН

Цэвэгжавын Нямдорж - Сумын ИТХ-ын дарга

Жамьяны Даваахүрэл - "Багашанд" ХХК-ний захирал

Жангаагийн Нямсүрэн - Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн мэргэжилтэн,
мастер
Доржийн Баянхишиг - "Өрнөлт Сэлэнгэ" ХХК-ний трактор-комбайнч
Банзрагчийн Гомбодорж - "Эм Энд Эм" ХХК-ний трактор-комбайнч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ

Шаравын Жанцан - "Газрын Ундраа" ХХК-ний трактор-комбайнч
Бэгзийн Эрдэнэбат - "Цэгээн хуст" ХХК-ний трактор-комбайнч
Дашнямын Жамсран - "Бүрэн Бүрд" ХХК-ний трактор-комбайнч
Хандсүрэнгийн Баатар - "Мөнхям" ХХК-ний трактор-комбайнч
Самбуугийн Бат-Очир - Цант хоршооны агнуурчин

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТОГТООЛ

2009 оны 7 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 223

Улаанбаатар
хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Ан агнуурын тухай хуулийн 8.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Тусгай зориулалтаар 2009 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 140 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлд "идлэг шонхор шувуу 240" гэснийг "идлэг шонхор шувуу 300" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Л.ГАНСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТОГТООЛ

2009 оны 7 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 225

Улаанбаатар
хот

Зарим төслүүдийн санхүүжилтийн тухай

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг хангах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт зам, тээвэр, барилга, хот байгуулалтын салбарт дэвшүүлж байгаа зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэд бүтцийн салбарт хэрэгжүүлэхээр заасан 100 мянган айлын орон сууц, говийн болон зүүн бүсийн төмөр зам, Улаанбаатар хотын автозам, гүүрийг шинэчлэх төслүүд болон шинээр 4500 км автозам барихад газрын тосны бүтээгдэхүүний урьдчилсан төлбөр авах, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу зарим тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх, Засгийн газрын бонд борлуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөрөнгө оруулалт хийх, тусгай зөвшөөрөл нь төрийн өмчит хуулийн этгээдэд байгаа томоохон ордуудыг хамтран ашиглах хөрөнгө оруулагчдаас урьдчилгаа төлбөр авах замаар төслүүдийг санхүүжүүлэх чиглэл баримтлан ажиллаж, холбогдох тооцоо судалгаа гарган тухай бүр Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр болон Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Х.БАТТУЛГА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТОГТООЛ**2009 оны 7 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 227

Улаанбаатар
хот**Журам батлах тухай**

Ойн тухай хуулийн 4.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Ойн сангийн тодорхой хэсгийг энэхүү журмын дагуу нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх замаар ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах ажлын үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг гарахаас өмнө ойн санг гэрээгээр эзэмшиж байсан нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагатай энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлээр баталсан журмын дагуу шинээр гэрээ байгуулж, гэрчилгээ олгох арга хэмжээ авч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 125 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД****С.БАЯР****БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД****Л.ГАНСҮХ****Засгийн газрын 2009 оны 227 дугаар
тогтоолын хавсралт****ОЙН САНГ ГЭРЭЭГЭЭР ЭЗЭМШҮҮЛЭХ ЖУРАМ****Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэхэд энэ журмыг дагаж мөрдөнө. Ойн сангийн тодорхой хэсэг гэж сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас



тухайн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэхээр олгосон ойн сангийн талбайн хэмжээг хэлнэ.

1.2. Энэхүү журмын зорилго нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад түшиглэсэн хамтын эзэмшлийн ойн менежментийг хөгжүүлэх, тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын тогтвортой үйл ажиллагааг дэмжихэд оршино.

1.3. Ойн нөхөрлөл гэж Ойн тухай хуулийн 3.1.8-д заасны дагуу зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллагыг хэлнэ.

1.4. Ойн санг гэрээгээр эзэмших аж ахуйн нэгж, байгууллагад ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий аж ахуйн нэгж, сургалт, эрдэм шинжилгээний болон ойн чиглэлийн төрийн бус байгууллага хамаарна.

1.5. Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх ойн сангийн талбайн хэмжээг нөхөрлөлийн гишүүдийн болон аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын тоо, чадавхи, хүчин чадал, дундын мөнгөн сангийн хэмжээ, тухайн ойн төлөв байдал, ойн талбай, нөөц, экологийн онцлогийг харгалзан тогтооно. Нөхөрлөлийн нэг гишүүнд ногдох талбай 500 га-гаас, аж ахуйн нэгж, байгууллагад ногдох талбай 15000 га-гаас ихгүй байна.

1.6. Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь зөвхөн нэг сум, дүүргийн нутаг дэвсгэр дэх ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшиж болно.

1.7. Нөхөрлөлийн ахлагч нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн байнгын оршин суугч байна.

1.8. Ойн санг гэрээгээр эзэмших нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээ болон гэрчилгээний загварыг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

Хоёр. Ойн санг эзэмших хүсэлт гаргах, шийдвэрлэх

2.1. Ойн санг гэрээгээр эзэмшихийг хүссэн нөхөрлөл тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүсэлт гаргана. Хүсэлтэд дараахь баримт бичгийг хавсаргасан байна:

2.1.1. ойн санг гэрээгээр эзэмшихийг хүссэн өргөдөл;

2.1.2. ойн санг гэрээгээр эзэмшихийг зөвшөөрсөн тухай баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал;

2.1.3. ойн менежментийн төлөвлөгөө, гэрээний төсөл, гэрээгээр эзэмших ойн талбайн хилийн цэс, байршил, тархалтын тойм зураг;

2.1.4. нөхөрлөлийг байгуулсан гишүүдийн хамтран ажиллах тухай гэрээний хуулбар;

2.1.5. нөхөрлөлийн гишүүдийн иргэний үнэмлэхийн хуулбар.

2.2. Нөхөрлөлийн гишүүд хамтран ажиллах тухай гэрээндээ нөхөрлөлийн оноосон нэр, хаяг, байршил, албан бичгийн нүүр, тэмдэг, дундын сангийн эд хөрөнгийн төрөл, хэмжээ, дансны дугаар, дундын хөрөнгө захиран зарцуулах, нөхөрлөлд элсэх, гарах журам болон гишүүний эрх, үүрэг, нөхөрлөлийн хурлаар хэлэлцэх асуудал, нөхөрлөлийн удирдлагыг сонгох журам, нөхөрлөлийн үйл ажиллагаа, түүнийг татан буулгах зэрэг асуудлыг тусгасан байна.

2.3. Ойн санг гэрээгээр эзэмшихийг хүссэн аж ахуйн нэгж, байгууллага тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүсэлт гаргана. Хүсэлтэд энэ журмын 2.1.1-2.1.3-т зааснаас гадна дараахь баримт бичгийг хавсаргасан байна:

2.3.1. ойн чиглэлийн үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагын олгосон гэрчилгээний хуулбар;

2.3.2. аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн болон техник, технологийн чадавхи, үйлдвэрлэлийн байрны талаархи тухайн орон нутгийн байгаль орчны, эсхүл ойн байгууллагын тодорхойлолт.

2.4. Энэхүү журмын 2.1, 2.3-т заасан баримт бичгийг бүрдүүлэн, Ойн тухай хуулийн 18.6-д заасан шаардлагыг хангасан бол сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал асуудлыг хурлаараа хэлэлцэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн санг гэрээгээр эзэмшүүлэх тухай шийдвэр гаргана.

Гурав. Ойн санг эзэмшүүлэх гэрээ байгуулах, сунгах

3.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагатай ойн санг эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгоно.

3.2. Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь хугацаагаа сунгуулах хүсэлтээ гэрээний хугацаа дуусахаас 3 сарын өмнө сум, дүүргийн Засаг даргад гаргана. Гэрээний хугацаа сунгах хүсэлтэд тухайн сумын буюу сум дундын ойн анги, ойн ангигүй газарт байгаль хамгаалагчийн уг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын гэрээ, менежментийн төлөвлөгөөний биелэлтэд өгсөн үнэлгээг хавсаргасан байна.

3.3. Тухайн сумын буюу сум дундын ойн анги, ойн ангигүй газарт байгаль хамгаалагчийн өгсөн үнэлгээг үндэслэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын гэрээг Ойн тухай хуулийн 4.5-д заасан хугацаагаар сум, дүүргийн Засаг дарга сунгана.

Дөрөв. Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын бүрэн эрх

4.1. Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь Ойн тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараахь эрх, үүрэгтэй байна:

4.1.1. эзэмшлийн ойд хяналт шалгалт зохион байгуулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох, учруулсан хохирлыг буруутай этгээд, аж ахуйн нэгж, байгууллагаар нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах, шаардлагатай бол хуулийн байгууллагад асуудлыг тавих;

4.1.2. эзэмшлийн ойг түймрээс сэргийлэх, хавар, намрын хуурайшилт ихтэй үед байнгын эргүүл, жижүүр ажиллуулах, сум, дүүргийн Засаг дарга болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд тогтоосон хугацаанд мэдээлэл өгч байх, түймэртэй тэмцэх, түүний хор уршгийг арилгах арга хэмжээ авах;

4.1.3. эзэмшлийн ойн сангийн газар, ус, ургамал, амьтны аймаг, бусад байгалийн баялгийг хамгаалах, төрх байдлыг хадгалах арга хэмжээ авах;

4.1.4. ойн сангийн өөрчлөлтийг жил бүр гаргаж байх, байгалийн бусад баялгийн өөрчлөлтөд тогтмол ажиглалт хийж, үнэн зөв мэдээллийг ойн анги эсхүл байгаль хамгаалагчид өгч байх;

4.1.5. эзэмшлийн талбайдаа ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах ажлыг өөрийн хөрөнгөөр болон бусад байгууллагын дэмжлэгтэйгээр гүйцэтгэх, шаардлага хангасан таримал ойг зохих хугацаанд нь улсын ойн мэдээллийн санд бүртгүүлэх;

4.1.6. ойд зорчин явагсад, байгалийн тодорхой баялгийг ашиглагчдад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, мөрдүүлэх, гаргасан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

4.1.7. ан амьтан, загас, шувуу зэрэг биологийн төрөл зүйл болон гол горхи, булаг шандны эх, хөвөө, хадлан бэлчээрийн талбайг хамгаалах, нөхөн сэргээх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх;

4.1.8. хуульд заасан хугацаанд нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь эзэмшиж, ашиглаж байгаа ойн санд ой зохион байгуулалтыг хийлгэсэн байх;

4.1.9. ойн нөхөрлөл нь мод болон ойн дагалт баялгийг борлуулснаас олсон нийт орлогын 50-иас доошгүй хувийг дундын санд төвлөрүүлж, энэ орлогыг ойг түймрээс урьдчилан сэргийлэх, хууль бусаар мод бэлтгэхийг таслан зогсоох, хяналт тавих, ойг нөхөн сэргээх, нутгийн хөгжлийг дэмжихэд зарцуулах.

Тав. Гэрээг цуцлах

5.1. Ойн тухай хуулийн 18.10, 19.2-т заасны дагуу тухайн сум, дүүргийн Засаг дарга ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТОГТООЛ

2009 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 234

Улаанбаатар
хот

Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө бэлтгэх ажлыг журамлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Төрийн өмчит хуулийн этгээдэд тухайн жилд шаардагдах үндсэн хөрөнгийг төвлөрүүлэн хангах ажлыг нэгтгэн зохион байгуулж, бүртгэлийн нэгдсэн санд хөдөлгөөн хийж, хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд үүрэг болгосугай.

2. Төрийн өмчит хуулийн этгээд нь дараа онд хэрэгцээтэй байгаа үндсэн хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, тэдгээрийг худалдан авахад шаардагдах зардлын төсвийн төслийн саналыг тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний дотор Төрийн өмчийн хороонд ирүүлж байхаар тогтоосугай.

3. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө худалдан авахаар ирүүлсэн саналыг хэрэгцээ шаардлагад нь үндэслэн хянаж батлан, тухайн жилийн 7 дугаар сарын 15-ны дотор Сангийн яаманд хүргүүлж байхыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

4. Төрийн өмчийн хорооноос хянан баталсан энэхүү тогтоолын 3 дугаар зүйлд заасан саналыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын дараа оны төсвийн багцад тусгаж байхыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгорт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Б.ДОЛГОР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТОГТООЛ

2009 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 239

Улаанбаатар
хот

Үндэсний стратегийг сайшаах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн яамнаас боловсруулсан “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийг сайшаасугай.

2. “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги” болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтран баталж, хэрэгжилтийг зохион байгуулан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт даалгасугай.

3. “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл болон төсөвт тусгах, хандивлагчдын зээл тусламж авах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

4. Үндэсний стратегийн зорилт болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТОГТООЛ

2009 оны 8 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 246

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Эмч, багш нарыг цэргийн дүйцүүлэх алба хаасанд тооцох алслагдсан сумдын жагсаалт"-ыг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Л.БОЛД

Засгийн газрын 2009 оны 246 дугаар
тогтоолын хавсралт

ЭМЧ, БАГШ НАРЫГ ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА ХААСАНД ТООЦОХ АЛСЛАГДСАН СУМДЫН ЖАГСААЛТ

№	Аймаг	Сумын нэр
1	Архангай	Жаргалант
2		Хангай
3		Цэцэрлэг
4	Баян-Өлгий	Булган
5		Дэлүүн
6	Баянхонгор	Баянговь
7		Баянлиг
8		Баян-Өндөр
9		Жаргалант
10		Гурванбулаг
11		Хүрээмарал
12		Заг
13		Шинэжинст



14	Булган	Тэшиг
15	Говь-Алтай	Дарви
16		Тонхил
17		Хөхморьт
18		Бугат
19		Чандмань
20		Эрдэнэ
21	Дорноговь	Хөвсгөл
22		Мандах
23		Дэлгэрэх
24		Иххэт
25	Дорнод	Баяндун
26		Дашбалбар
27		Матад
28	Дундговь	Өндөршил
29		Баянжаргалан
30		Цагаандэлгэр
31		Дэлгэрхангай
32		Сайхан-Овоо
33	Завхан	Асгат
34		Сантмаргац
35		Дөрвөлжин
36		Түдэстэй
37		Ургамал
38		Завханмандал
39		Сонгино
40		Баянхайрхан
41		Тэс
42	Цэцэн-Уул	
43	Өвөрхангай	Баруунбаян-Улаан
44		Богд
45	Өмнөговь	Гурвантэс
46		Манлай
47		Баян-Овоо
48		Ноён
49		Сэврэй



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТОГТООЛ

2009 оны 8 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 252

Улаанбаатар
хот

Тэмцээн зохион байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дэлхийн цомын аварга шалгаруулах эмэгтэйчүүдийн шатрын тэмцээнийг 2010 оны 7 дугаар сард, Дэлхийн цомын аварга шалгаруулах жудо бөхийн тэмцээнийг 2010 оны 10 дугаар сард Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулахаар тогтсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг 2010 оны төсвийн багцдаа тусган санхүүжүүлж, тэмцээний бэлтгэлийг бүрэн ханган, өндөр хэмжээнд зохион байгуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТОГТООЛ

2009 оны 8 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 254

Улаанбаатар
хот

Нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төв аймгийн "Монгол туургатан" театрыг Монгол Улсын Ардын жүжигчин, Төрийн хошой шагналт, хөгжмийн зохиолч Билэгийн Дамдинсүрэнгийн.

2. Нийгмийн ухааны дээд сургуулийг Төрийн хошой шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Шагдаржавын Нацагдоржийн.

3. Ховд аймгийн Хөгжимт драмын театрыг Монгол Улсын Ардын жүжигчин, Төрийн шагналт Жамъянгийн Чулууны.



4. Төв аймгийн Баян сумын ерөнхий боловсролын сургуулийг Монгол Улсын Төрийн шагналт зураач Батцэндийн Пүрэвсүхийн.

5. Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийг Монгол Улсын Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан Гүржавын Тувааны.

6. Улаанбаатар төмөр замын Сэлэнгэ аймгийн Сүхбаатар зүтгүүрийн депог Монгол Улсын гавьяат тээвэрчин Даваагийн Дамбийбалжирын.

7. Архангай аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийг Монгол Улсын гавьяат багш Төгсцогтын Нямдоржийн.

8. Дундговь аймгийн Сайнцагаан сумын ерөнхий боловсролын IY дунд сургуулийг Монгол Улсын гавьяат багш Намжилын Өлзийн.

9. Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургуулийг Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Гэлэгжамцын Лувсанцэрэнгийн.

10. Хавдар судлалын үндэсний төвийг Монгол Улсын хүний гавьяат эмч Намхай-Очирын Нямдаваагийн.

11. Архангай аймгийн Цахир сумын соёлын төвийг Монгол Улсын гавьяат жүжигчин Ванчинсүрэнгийн Оросоогийн нэрэмжит тус тус болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТОГТООЛ

2009 оны 8 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 255

Улаанбаатар
хот

**Газрын тосны бүтээгдэхүүний үнийн
өсөлтийн эсрэг авах зарим арга
хэмжээний тухай**

Онцгой албан татварын тухай хуулийн 6.7, Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшний

гаалийн албан татварын хэмжээг 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн "О" байхаар тогтоосугай.

2. Импортоор оруулж байгаа дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн импортоор оруулж байгаа хилийн боомтоос үл хамааруулан тонн тутамд 49000 (дөчин есөн мянган) төгрөг байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газрын тосны бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 203 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "автобензин, дизелийн түлшний" гэснийг "автобензиний" гэж өөрчилж, "Газрын тосны бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2008 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 8 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "гаалийн албан татварыг "5" хувиар" гэснийг 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТОГТООЛ

2009 оны 8 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 257

Улаанбаатар
хот

Агентлаг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, 6.3-т заасныг болон "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" Улсын Их Хурлын 2009 оны 43 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мэргэжлийн боловсрол, сургалтын газар байгуулсугай.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталж мөрдүүлэхийг



Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаярт даалгасугай.

3. Мэргэжлийн боловсрол, сургалтын газрыг үйл ажиллагаа явуулах ажлын байраар хангах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 64 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт"-ын "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсэгт Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд "Мэргэжлийн боловсрол, сургалтын газар" гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Е.ОТГОНБАЯР

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2009 оны 10 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 44 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 44.4. ДЭХ ХЭСГИЙГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4. дэх хэсгийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн Хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:**

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4.-т заасан "төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд" гэдэгт энэ хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.-д заасан хэргийн оролцогч хамаарахгүй.



Мөн хэсэгт заасан “бичмэл нотлох баримт” гэдэгт хуулийн 38 дугаар зүйлийн 38.6. дахь хэсэг, 12-14 дүгээр бүлэгт заасан үндэслэлээр шүүхийн бүрдүүлэх нотлох баримт хамаарна.

Энэ хэсэгт заасан “өөрийн байгууллагын архивын “хуулбар үнэн” гэсэн тэмдэг дарж баталгаажуулна” гэдгийг тухайн байгууллага, хуулийн этгээдийн албан хэрэг хөтлөлтийн талаар дотооддоо баримталдаг болон нийтээр даган мөрддөг дүрэм, журмын дагуу баримт бичгийн хуулбарын үнэн зөвийг тодорхойлсон архив буюу бичиг хэргийн нэгжийн эрх бүхий албан тушаалтан тэмдэглэгээ бүхий дардас дарж, гарын үсгээ зурсан байхыг ойлгоно.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай 2009 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хууль Улсын бүртгэлийн ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4.-т заасан зохицуулалтыг 2009 оны 07 дугаар сарын 26-ны өдрөөс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтална.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**С.БАТДЭЛГЭР
ЦАМАРСАЙХАН**

Залруулга

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2009 оны 01 сарын 28-ны өдрийн 4 /577/ дугаарын 69 дүгээр хуудсанд нийтлэгдсэн Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн огноог “2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр” гэснийг “2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр” гэж залруулан уншина уу.

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редакци.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редакци


Улаанбаатар-12, Төрийн ордон 128 тоот

И-мэйл: tunin_medeelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 1.5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487